



**Үйлийг тоочин дүрсэлсэн
эхийн бүтцийг задлан
шинжилж, үндсэн шинжийг
ялган таних**




Гадаад ба дотоод шинжийг тоочин дүрсэлж бичих арга

Зохиогчийн сонин
содон дүрслэлийг
ашиглан шинжийг
тоочин дүрсэлж
бичих

Эсрэг ба ойролцоо
утгатай нийлмэл үг
ашиглан шинжийг
тоочин дүрсэлж
бичих

Тэмдэг нэр
ашиглан шинжийг
тоочин дүрсэлж
бичих



Аян замын тэмдэглэл



Аялсан газрын сонин содон зүйл, хүмүүсийн аж амьдрал, зан заншил, байгалийн өвөрмөц сонин тогтоц, өнгө төрх, үзэгдэл, үйл явц зэргийг уншигчдад сонирхуулах, танин мэдүүлэх зорилгоор бичигдсэн тэмдэглэлийг аян замын тэмдэглэл гэдэг.

Аян замын тэмдэглэл бичихдээ хэрэг явдал хэзээ, хаана болж байгаа нь тодорхой байх ёстой.

Аян замын тэмдэглэлд хамгийн чухал, сонин сайхныг бичихийн тулд зохиогчоос ажигч гярхай чанар, бичих зүйлийн талаар өргөн дэлгэр мэдлэг шаарддаг.

Аяллын тухай өвөрмөц, сонин содон үг хэллэг, дүрслэлийг ашиглан, уншигчдын сэтгэлд бууж, нүдэнд харагдтал бичсэнээр тэднийг шинэ сонин аян замд хөтөлнө.



Аян замын тэмдэглэл

Аян замын
тэмдэглэлийн
зорилго юу
вэ?

Аяллынхаа
Юу Юуг?,
Яаж? тоочин
дүрсэлж
бичсэн байна
вэ?

Аяллынхаа
тухайд ямар
сонин содон
үг хэллэг
хэрэглэсэн
байна вэ?

Аяллын
тэмдэглэлээс
ямар шинэ
мэдээлэл олж
мэдэх вэ?

Аяллын сонин
сайхныг
уншигчдын
сэтгэлд бууж,
нүдэнд
харагдтал
хэрхэн бичих
вэ?



Ц.Гомбожавын “Монгол Төвөдөөр аялсан тэмдэглэл”-ийн хэсгийг уншъя.

5

1899 оны 1 сарын 25. Өргөө хот. Шарын шашны бурхан шүтээнд мөргөхөөр яваа буриад ламын дүрээр хувцасласан миний бие дөрвөн тэмээ хөллөн, Алшаагийн монгол жинчидтэй хамт Өргөөгөөс хөдөллөө...

1901 оны 2 сарын 7. Лхас. Орон нутгийн тооллоор цагаан сар (төвөдөөр лосар) гарлаа. Энэ өдөр хотын ард иргэд үүр гэгээрэхээс өмнө босож, эхлээд гэртээ, дараа нь Зуу сүмд мөргөл үйлдэнэ. Үүр цайх үеэр тусгай домботой арвайн дарс, тавагтай замбаа барин танил, хөрш айлууддаа орж, идээ амсуулна. Тавагтай замбаагаа шовойлгон янзлаад дээр нь өвсөн иштэй, тосоор урласан цэцэг хатгана. Үүнийгээ чимар (тостой замбаа) гэж нэрлэнэ. Энэ идээгээр дайлуулсан хүн замбаанаас чимхэн авч бурхан тэнгэрт өргөнө. Өөрөө мөн чимхэн авч хүртэнэ. Домботой дарснаас амсана. Энэ өдөр айлд орсон хүнийг мөн ийм идээгээр дайлна. Зуу сүмд бүхэл өдөржин мөргөл үргэлжилнэ. Хүүхэд, томчууд ч ялгаагүй чүдэнз зурж, харанхуйд ягаан гэрэл гарган наадна. Гудамжинд хэсэг хэсгээрээ дуу дуулан бүжнэ. Залуу бүсгүйчүүд дээс тоглон цэнгэн наадна.

1902 оны 4 сарын 27. Өргөө. Нутаг буцахаар Монголын өртөөгөөр гарч 5 сарын 2-нд Хиагт хотоор эх орныхоо алтан хилийг алхан орлоо.

Танил бус үгийн утгыг



Алшаа- БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны аймгийн нэр
Лхас – БНХАУ-ын Төвөдийн өөртөө засах орны нийслэлийн нэр
Үүр гэгээрэх- бараг бүрэг гэгээ орох
Үүр цайх- гэгээ орох
Зуу сүм- мөргөлийн газар
Замбаа-хуурсан арвайн гурил
Чимар- тостой арвайн гурил



1899 оны 1 сарын 25. Өргөө хот. Шарын шашны бурхан шүтээнд мөргөхөөр яваа буриад ламын дүрээр хувцасласан миний бие дөрвөн тэмээ хөллөн, Алшаагийн монгол жинчидтэй хамт Өргөөгөөс хөдөллөө...

1901 оны 2 сарын 7. Лхас. Орон нутгийн тооллоор цагаан сар (төвөдөөр лосар) гарлаа. Энэ өдөр хотын ард иргэд үүр гэгээрэхээс өмнө босож, эхлээд гэртээ, дараа нь Зуу сүмд мөргөл үйлдэнэ. Үүр цайх үеэр тусгай домботой арвайн дарс, тавагтай замбаа барин танил, хөрш айлууддаа орж, идээ амсуулна. Тавагтай замбаагаа шовойлгон янзлаад дээр нь өвсөн иштэй, тосоор урласан цэцэг хатгана. Үүнийгээ чимар (тостой замбаа) гэж нэрлэнэ. Энэ идээгээр дайлуулсан хүн замбаанаас чимхэн авч бурхан тэнгэрт өргөнө. Өөрөө мөн чимхэн авч хүртэнэ. Домботой дарснаас амсана. Энэ өдөр айлд орсон хүнийг мөн ийм идээгээр дайлна. Зуу сүмд бүхэл өдөржин мөргөл үргэлжилнэ. Хүүхэд, томчууд ч ялгаагүй чүдэнз зурж, харанхуйд ягаан гэрэл гарган наадна. Гудамжинд хэсэг хэсгээрээ дуу дуулан бүжнэ. Залуу бүсгүйчүүд дээс тоглон цэнгэн наадна.

1902 оны 4 сарын 27. Өргөө. Нутаг буцахаар Монголын өртөөгөөр гарч 5 сарын 2-нд Хиагт хотоор эх орныхоо алтан хилийг алхан орлоо.

1. Эхийн агуулгын бүтцийг тодорхойлоорой.
- 2.. Хэсэг тус бүрд юуны тухай өгүүлсэн бэ?
3. Эхэд юуг тоочин дүрсэлсэн байна вэ?
4. Эхээс ямар шинэ сонирхолтой мэдээлэл олж авсан бэ?
5. Эхийн өгүүлбэрүүдийн хэлбэржилтийг ажиглаарай.
6. Зохиогч аян замын тэмдэглэлээ тоочих хэв маягаар бичсэнийг батлаарай.

Эхийг задлан шинжилье

Эхийн агуулгын бүтэц	Хэсэг	Эхэд ямар үйл явдал дүрслэгдэж байна вэ?	Шинэ мэдээлэл
Эхлэл	1899 оны 1сарын 25. Өргөө хот. Шарын шашны бурхан шүтээнд мөргөхөөр Өргөөгөөгөөс хөдөллөө.	Өргөө хотоос Лхас хотод очин бурхан шүтээнд мөргөхөөр явж буй үйл явдал	Төвөдийн ард түмний цагаан сараар үйлддэг сонирхолтой зан үйлийн тухай
Гол	1901 оны 2сарын 7. Лхас. Орон нутгийн тооллоорцэнгэн наадна .	Очсон газрын сонин сайхныг тоочин өгүүлсэн	
Төгсгөл	1902 оны 4 сарын 27. Өргөө. Нутаг буцахаар.....хилийг алхан орлоо.	Нутаг нутаг буцаж буй тухай.	

Ард иргэд	Өмнө босо ж ,	
		мөргөл үйлдэ нэ
	арвайн дарс барин н ,	
	тавагтай замбаа барин н ,	
	хөрш айлууддаа ор ж ,	
		идээ амсуул на .
	шовойлгон янзлаа д ,	
		цэцэг хатга на .
Хүн		гэж нэрлэ нэ .
	чимхэн ав ч ,	
Өөрөө		бурхан тэнгэрт өргө нө .
		авч хүртэ нэ .
		дарснаас амса на .
Хүүхэд , томчууд ч		идээгээр дайл на .
	чүдэнз зур ж ,	
		гэрэл гарга на .
бүсгүйчүүд		дуу дуулан бүж нэ .
	дээс тогло н ,	
		цэнгэн наад на .

1. Өгүүлбэрийн үйлийн хэлбэржилтийг ажиглаарай.

2. Зохиогчийн аян замын тэмдэглэлээ тоочих хэв маягаар бичсэнийг батлаарай.



- ❑ Өгүүлбэрүүд хоорондоо үйлийн зэрэгцүүлэн холбох **-ж, ч**, хам холбох **-н**, урьдчилан холбох **-аад**, нөхцлүүдээр хэлбэржин холбогдож үйлүүд нь нэг цагт зэрэгцэн болж буй утгыг илэрхийлсэн.
- ❑ Өгүүлбэрүүдийг бүгд цагаар төгсгөх **– на** нөхцөлөөр төгсгөж, хүмүүсийн хийж буй үйлийг тоочин бичсэн.

"ЭКВАДОРТ ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ"-ээс



... Уулын сүрд дарагдан бидний зүрх түгшлээ. Гурван мянган метр өргөгдсөн их уулын сүрлэг хяр дээгүүр, гүн ангал, хадан хясааны ирмэгээр, могой мэт тахиралдсан нарийхан замаар бидний суусан автобус уухилан дээшилсээр байлаа. Зарим газар замын хажуугийн эгц энгэр нурж бөөн чулуу шороо овоологдсон, зарим газар үер бууж замын дундуур сэт цохигдсон байлаа.

Тэр бүхнийг тойрох, дээгүүр нь дэнжигнэн тэгнэх, гулсан хий эргэх зэргээр гэтлэн давахын тулд автобус, жолооч хоёр зовон зүдэж, дотор нь суусан бид айн бэмбэгнэн явсаар арай гэж даваан дээр гарав. Эргэн харахад тэртээ дор ширүүн урсгалт гол, хадан хясаа, гүнзгий хавцал дундуур гаслах мэт бархиран урсаж, алсад Антисанаа гэдэг сүрлэг цаст уулын орой цайвалзан цухуйж үзэгдлээ.

Эквадорын арван найман мужийн нэг болох Имбабура орохоор бид ийнхүү бэдэрч явна. Даваан дээр гартал алсад бас шовх цэнхэр уулс сүндэрлэн давхарлаж, хэрэм мэт хүрээлэн харагдлаа. Бидний өмнүүр хөндөгдөн цэнхэртэх уулсаас янагш цэлгэр ногоон хөндий мэлтийж, тэртээ үзүүрт нь тогорууны нүд шиг нуур гялтайж байлаа. Даваан дээр гарч тонгоймогц автобус зогсоход бид ухасхийн үүд зүглэлээ.

Биднийг газардмагц өмнөөс минь сонин хувцастай нэгэн эр угтан ирлээ. Хөхөлбий бор царайтай, намхан нуруутай инка хүн ажээ. Мөрөндөө гитар хөгжим зүүжээ. Өвдөгнөөсөө доош саглагар хүрэн үстэй баавгайн годын сарвууг нь уруу харуулан унжуулсан нь мөчид харвал, хоёр хөл нь баавгайнх шиг юм. Инка хүмүүс баавгайн хумс бүхий сарвуутай годоор хийсэн уутыг өвдөгнөөс доош шилбээ дагуулан унжуулж өмд мэтээр өмсдөг байна. Анх харахад цочмоор сүртэй үзэгдэнэ. Тийнхүү бидэнтэй даваан дээр учирсан инка хүн гитараа хөндлөн барьж зогсоод эртний индейчүүдийн сонин дууг хөгжимдөж эхэллээ. Бид сонинучирхан түүнийг тойрч зогсоод дууг чгнав. Уянгалаг аялгуу байлаа. Гунигтай, анигар хүрэн нүдэнд нь уярал тодорч, үрчлээт мангай нь үе үе тэнийж, өвдөг рүүгээ унжуулсан баавгайн годны сарвуу нь үл мэдэг чичрэгнэнэ. Нэг үе гаслан уйлах шиг, нэг үе хилэгнэн зүхэх шиг, тэгснээ эхэр татан зогсох адил дуу аялгуу гитарын утаснаас цацагдан түгж, их уулын сийрэг агаарт тодхон цуурайтаж байлаа.

... Сүүлчийн бизон эсвэл сүүлчийн оронго үхэж тийнхүү аль нэгэн ховор амьтан байхгүй болсон тухай мэдээг дэлхий дахин эмгэнэн сонссон нь олонтоо. Гэвч индейчүүдийг ийм гунигт тавиланд хүргэхийг хүн төрөлхтөн хэрхэвч зөвшөөрөх ёсгүй. Эквадорын индейчүүд ...мөхөж сөнөхийн даваанд хүрсэн үедээ 1823 онд маршал Сүкрегийн удирдсан зэвсэгт тэмцлийн ачаар аврагджээ. "Идсэн эрүү хувхайрч, идүүлсэн бут ургана" гэгчээр харийн тонуулчид индейчүүдийг дуусгаж чадсангүй, пүүгээгээ үүрээд далайн чанадыг зүглэх цаг нь иржээ.

... Индейчүүд ирээдүйдээ итгэл алдсангүй. "Кунан кайа, Майжан, Пуньяа, инти чинг танга" гэж дуулсанар иржээ. Энэ нь "Өнөө юу, маргааш уу? Өөр нэг өдөр үү? Наран гарахлаа л нэг гарна" гэсэн утгатай юм санжээ. Индейчүүдийн жаргалын нар

Эхийг агуулгын бүтцээр зааглан, хэсэг тус бүрийн гол санааг ярилцъя

Эхээс зохиогчийн бүтээсэн сонин содон үг хэллэгийг тодруулан, яагаад сонгон хэрэглэх болсон шалгааныг тайлбарлая.

Эхэд уран дүрслэл ашигласан байна ?

Эхэд юу юуг зэрэгцүүлэн дүрсэлсэн байна вэ? Үүгэрээ зохиогч ямар санаа илэрхийлж байгааг мэдье.

Эхээс ямар ямар шинэ мэдээлэл мэдэж авсан бэ?



Эхийн агуулгын бүтэц	Эхэд юуны тухай өгүүлсэн бэ? Ямар асуудлыг хөндсөн бэ?	Зохиогчийн сонин содон үг хэллэг	Уран дүрслэл	Эхэд юу юуг зэрэгцүүлэн дүрсэлсэн байна вэ?	Шинэ мэдээлэл
<p>Эхлэл хэсэг</p> <ul style="list-style-type: none"> ...Уулын сүрд дарагдан..... ... бид ухасхийн үүд зүглэлээ. <p>Гол хэсэг</p> <ul style="list-style-type: none"> Биднийг газардмагц..... цуурайтаж байлаа. <p>Төгсгөл хэсэг</p> <ul style="list-style-type: none"> ...Сүүлчийн бизон эсвэл.....жаргалын нар гарах өдөр ойрхон болжээ. 	<p>Эквадорын инга овгийнхон буюу индейчүүдэд мөхөх аюул нүүрлэж буй тухай өгүүлсэн</p>	<ul style="list-style-type: none"> Могой мэт тахиралдсан нарийхан зам – өндөр уулын замын харагдах хэлбэр хэмжээг дүрсэлсэн- адилтгал Автобус уухилан дээшилсээр- өгсүүр замд автобусны арай ядан явж буй байдлыг дүрсэлсэн. Гол...гаслах мэт бархиран урсаж- хадан хясаа хавцал 2 т хашигдан урсаж буй голыг дүрсэлсэн Шовх цэнхэр уулс сүндэрлэн давхарлаж, хэрэм мэт хүрээлэн- уулсын харагдах байдлыг Цэлгэр ногоон хөндий мэлтийж- Тэртээ үзүүрт нь тогорууны нүд шиг нуур гялтайж- хөндийд харагдах жижигхэн нуурын хэмжээг тогорууны нүдтэй адилтгаж дүрсэлсэн. Нэг үе гаслан уйлах шиг, нэг үе хилэгнэн зүхэх шиг, тэгснээ эхэр татан зогсох адил дуу аялгуу- Гитарын утаснаас цацагдан түгж 	<ul style="list-style-type: none"> Зүрх түгшлээ- айх Идсэн эрүү хувхайрч , идүүлсэн бут ургана- эцэстээ шударга үнэн дийлдэг Итгэлд алдсангүй- хэлсэндээ байх Наран гарах- баярлах 	<ul style="list-style-type: none"> Эхлэл хэсэгт явсан газрын байгалийн байдал, хүрээлэн буй орчны онцлог дүр төрхийг зэрэгцүүлэн дүрсэлсэн. Имбабура мужийн инка хүний төрх байдлыг зэрэгцүүлэн дүрсэлсэн 	<ul style="list-style-type: none"> Эквадорын Имбабура мужийн байгалийн сонин сайхныг, инка хүний дүр төрх Эквадорын индейчүүдэд мөхөх аюул нүүрлэсэн ч тэд мөхөгүй. Хэзээ нэг цагт тэдэнд сайхан цаг ирнэ.

Үйлийг тоочин дүрсэлсэн эхийн үндсэн шинж

- Тухайн юмсын үйл хөдлөлийг тоочин бичнэ.
- Үйл явдал нь нэг цагт зэрэгцэн өрнөдөг.
- Өгүүлбэрүүд нь зэрэгцүүлэн холбох нөхцөл, холбох үгээр холбогддог.



- юмсын үйл хөдлөлийг тоочин бичнэ.
- Үйл явдал нь нэг цагт зэрэгцэн өрнөдөг.
- Өгүүлбэрүүд нь зэрэгцүүлэн холбох нөхцөл, холбох үгээр холбогддог.

Зохиогчийн бүтээсэн сонин содон үг хэллэг

Шинжийг тоочин дүрсэлсэн эхэд	Үйлийг тоочин дүрсэлсэн эхэд
Шинж чанар өнгө , зүс, хэлбэр хэмжээ заасан утгатай үгсийг илүү хэрэглэж тухайн хүний зан чанар , сэтгэл, дүр Төрхийг тодруулдаг.	Аялсан газрын онцлогийг уншигчдын сэтгэлд буутал дүрслэхийн тулд хэрэглэдэг.

- Уран дүрслэл
Эхэд далд ёгт, өргөн дэлгэр, гүн гүнзгий санааг илэрхийлэхийн тулд дүрслэлийг хэрэглэдэг
- Шинэ мэдээлэл
Уншигчдын танин мэдэхүйг тэлэх, сонирхлыг татах тухайн газар нутгийн байгаль , цаг уур, хүн зоны тухай шинэ сонин мэдээлэл



Анхаарал тавьсанд
баярлалаа.

